



БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ-Д

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жигжиджавын гудамж 3, Бодь Цамхаг
Утас: +976 7577 1199, И-мэйл: info@bogdbank.com
Вэб: www.bogdbank.com

2022.11.14 № 907
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Монголын хөрөнгийн бирж нь бүртгэлтэй хувьцаат компаниудынхаа мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй, түргэн шуурхай хүргэх, хөрөнгө оруулалтын илүү таатай нөхцөлийг бий болгох зорилгоор “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ыг МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 08 дугаар тогтоолоор баталж, СЗХ-ны даргын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 343 тоот тушаалаар батламжилж, мөн өдрөөс дагаж мөрдөхийг үүрэг болгосон билээ.

Дээрх журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 30-ны, 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг тус тус хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.САРУУЛ

0006413

Богд банк ХК-ны олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

2022 оны 09 сарын 30-ны өдрийн байдлаар

Богд банк нь 2021 оны 12 сард Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгон худалдах зөвшөөрлөө авч 31,750 сая төгрөгийг 7 хоногийн хугацаанд амжилттай татан төвлөрүүлсэн билээ.

Богд банк ХК нь IPO хийх хүсэлт болон холбогдох бичиг баримт, төсөв, төлөвлөгөөг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр МХБ, Монголбанк болон СЗХ-нд хүргүүлсэн бөгөөд зохицуулагч байгууллагуудын шаардлагаар дахин 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр шинэчлэн хүргүүлсэн. Монголбанк, СЗХ-ны хамтарсан журам болон бусад зөвшөөрлүүдийн хугацаа хойшилсоор 2021 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 1/4147 тоот албан тоотоор СЗХ-ноос Богд банкинд үнэт цаасаа олон нийтэд арилжих зөвшөөрлийг олгон 12 дугаар сарын 1-ээс 7-ны өдрүүдэд анхдагч захын арилжааг зохион байгуулж 12 дугаар сарын 13-ны өдрөөр холбогдох гүйлгээнүүд хийгдсэн тул 2021 онд төлөвлөж байсан зарцуулалтууд мөн хойшилсон болно.

Банк энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, банкны үйл ажиллагааг өргөжүүлж, апигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр зарцуулахаар төлөвлөсөн ба үнэт цаасны танилцуулгад тусгаснаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

№	Хөрөнгө оруулалтын төрөл /сая төгрөгөөр/	2021	2022	2023	НИЙТ	Хувь
1	Технологийн хөрөнгө оруулалт	2,540	7,303	2,858	12,700	40%
2	Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт	1,905	3,810	3,810	9,525	30%
3	Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт	2,778	3,523	3,224	9,525	30%
		7,223	14,636	9,891	31,750	100%

Хөрөнгө оруулалтын төрөл бүрийг задлан 2022 оны эцсийн байдлаарх төлөвлөгөөг 2022 оны 09 сарын гүйцэтгэлтэй харьцуулан гүйцэтгэлийг хувийг үзүүлбэл:

1. ТЕХНОЛОГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Банк нь технологийн хөрөнгө оруулалтад нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 40 хувийг зарцуулахаар төлөвлөсөн ба үүний 77.5% буюу 9.8 тэрбум төгрөгийг 2022 онд зарцуулахаар төлөвлөсөн. Нийт технологийн хөрөнгө оруулалтын 50 хувийг цахим бүтээгдэхүүн

үйлчилгээг хөгжүүлэхэд, 33 хувийг үндсэн томоохон систем сайжруулалт хөгжүүлэлтэд, үлдсэн 17 хувийг одоо байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулахад тус тус зарцуулахаар төлөвлөсөн билээ. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар тус хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

№	Хөрөнгө оруулалтын задаргаа	Төлөвлөгөө 2022 эцсээр *	Гүйцэтгэл 2022.09 байдлаар*	Гүйцэтгэл хувь
1	Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ	4,921	1,130	22.96%
2	Систем сайжруулалт хөгжүүлэлт	3,248	725	22.33%
3	Уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг цахимжуулах, сайжруулах	1,673	158	9.50%
		9,843	2,014	20.46%

*сая төгрөг

Банк нь цахим бүтээглэхүүн үйлчилгээ -ний хүрээнд одоо ашиглаж буй АТМ болон ПОС төхөөрөмжийн сүлжээний холболт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой худалдан авалт болон системийн хөгжүүлэлтийг төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд шинээр нэмж 1000 ширхэг ПОС төхөөрөмжийг шинээр худалдан авч, мөн ПОС терминалын системийн шаардлагыг сайжруулах зорилгоор cloud based TMS системийг үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна. Ингэснээр банкны ПОС төхөөрөмжүүд зайнаас нэгдсэн байдлаар шинэ update хөгжүүлэлтийг авах, В point оноогоор төлбөр тооцоо хүлээж авах, зайнаас буюу contactless картын гүйлгээ хүлээн авах гэх мэт шинэ боломжуудтай болсон.

Банк нь цахимаар банкны үйлчилгээг үзүүлэх зорилгоор өөртөө үйлчлэгч КИОСК төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөн холбогдох төхөөрөмж, системийн хөгжүүлэлтийг хийж дуусгаад байсан боловч шинээр батлагдсан “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийн хэрэгжилтийн хүрээнд төрийн үйлчилгээний хур системээс тодорхой хязгаарлалтуудтай тулгарснаар тухайн чиглэлийн хөрөнгө оруулалтыг түр хугацаагаар хойшлуулаад байна. Мөн банк нь CRM болон АТМ төхөөрөмжийн худалдан авалтын хувьд бэлэн мөнгөний хэрэглээ өндөр зах худалдааны төв түшиглэсэн салбар болон цэгүүдэд байршуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох байршлын судалгааны ажлууд хийгдэж байна. Банк нь эдгээр цэгүүдэд эхний ээлжинд өөрийн бодит салбараа байршуулсан /Хархорин, Яармаг, Драгон/ бөгөөд гүйлгээний дүн, давтамжаас шалтгаалан биет CRM байршуулах асуудлыг шийдвэрлэнэ. Нөгөө талдаа харилцагчдынхаа бэлэн мөнгөний хэрэгцээг шийдвэрлэх зорилгоор БАГЦЫН үйлчилгээгээ улам төгөлдөржүүлэн, сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байна. Харилцагч маань багц үйлчилгээнд хамрагдсанаар зөвхөн Богд банкны гэлтгүй бусад банкны АТМ, банк хоорондын гүйлгээнд шимтгэл төлөхгүй байх боломжтой юм.

Систем сайжруулалт хөгжүүлэлт-ийн чиглэлээр Банк нь шаардлагатай сүлжээний тоног төхөөрөмжийг худалдан авах, системийн төлбөрт нийт 725.41 сая төгрөгийг зарцуулаад байна.

Уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг цахимжуулах, сайжруулах чиглэлээр банк нь нийт гадны байгууллагуудаас шаардлагатай системүүдийг хийлгүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.

2. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН БОРЛУУЛАЛТЫН СУВГИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ, САЙЖРУУЛАЛТ

Банк нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 30 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг бүтээгдэхүүн үйлчилгээнд, мөн 30 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг борлуулалтын сувгийн хөгжүүлэлт сайжруулалтанд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд үүний 75 хувийг онлайн зээлд, үлдсэн 25 хувийг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн. Мөн цаг хугацааны хувьд 2022 он дуусахад тус чиглэлийн хөрөнгө оруулалтын 60 хувь буюу 5.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байх төлөвлөгөөтэй байна.


Тус хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг харвал:

№	Зарцуулалтын төрөл	Төлөвлөгөө 2022 эцсийн байдлаар	Гүйцэтгэл 2022.09 байдлаар	Гүйцэтгэл хувь
1	Зээлийн багц	4,286.4	21,390	499%
2	Бусад шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ	1,428.6	4,100	286%
3	Бусад салбарын техникийн хөрөнгө оруулалт		427.0	
		5,715.0	25,917.1	453%

**сая төгрөг*

Банк нь онлайн сувгаар онлайн хадгаламж барьцаалсан зээл, онлайн цалингийн зээл, шуурхай зээл гэсэн бүтээгдэхүүнийг олгож байгаа бөгөөд 2022 оны эхнээс өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 21,390 сая төгрөгийг онлайн сувгаар олгоод байна. Мөн шинээр энэ онд Экспресс автомашины зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд тайлант хугацааны байдлаар 4.1 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байна.

Онлайн сувгаар дамжуулан олгосон зээл /сая.₮/



Банк шинээр тайлант хугацаанд шинэ салбар байгуулах үйл ажиллагаанд нийт 427 сая төгрөгийг зарцуулаад байна.

2022 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар татан төвлөрүүлсэн 31,750 сая төгрөгөөс нийт 27,931 сая төгрөг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зарцуулагдсан байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл 3,819 сая төгрөг нь актив талд энгийн зээл олголтонд болон Төв банкны үнэт цаас, монголбанк дахь харилцах данс зэрэгт байршсан болно.